



**НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 06 дугаар сарын 08

Дугаар 06

Улаанбаатар хот

Тус газрын Даргын зөвлөлийн ээлжит хуралдааныг Нийслэлийн төр захиргааны IV байрны 11 давхарын 04 тоот хурлын зааланд 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 10 цаг 00 минутад эхлэв.

Хурлыг газрын дарга С.Жавхлантаатар удирдан явуулав.

Хуралд Захиргаа удирдлагын хэлтсийн хүний нөөцийн ахлах мэргэжилтэн А.Оргилсайхан, Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтсийн дарга Б.Дөлгөөн, Тээвэр төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Тамир, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Баярмаа, Хуулийн зөвлөх Б.Галсанжамц, Гэрээ хариуцсан хуулийн ажилтан Б.Баянзул, Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Б.Болорцэцэг нар оролцов.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын танилцуулга

Хэлэлцэх асуудал-1

А.Оргилсайхан: Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын танилцуулгыг Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Б.Болорцэцэг танилцуулна.

Б.Болорцэцэг: Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийслэл хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээнээс тус газрын хариуцах 1 арга хэмжээ байна. Төлөвлөгөөнд туссан үндсэн хариуцах 1 зорилт арга хэмжээний дундаж 70% буюу Олон төрөлт, ухаалаг нийтийн тээвэр хэрэглээнд нэвтэрсэн байна. Зорчигчдын ариун цэвэр, аюулгүй байдлыг хангасан, нийтийн тээврийн буудалтай байна. Хэрэгжилт 70 хувьтай байна. Тус газрын хариуцан хэрэгжүүлэхээр туссан арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 70%-тай байгаа нь 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6.2.3-т заасан үнэлгээний арга зүйгээр тодорхой үр дүнд хүрсэн буюу зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай үнэлгээтэй байна.


ШИЙДВЭРЛЭСЭН НЬ

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ

1. "Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хариуцаж байгаа холбогдох хэлтэс, нэгжийн дарга нар хэрэгжилт хангалтгүй байгаа ажлуудаа онцгой анхаарч цаашид эрчимжүүлж ажиллах;

2. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ийн дагуу өгөхөд анхаарч ажиллахыг холбогдох хэлтэс, нэгжүүдэд тус тус үүрэг болгов.

ТАНИЛЦСАН:
ДАРГА



С.ЖАВХЛАНТБААТАР

ХЯНАСАН:
ХҮНИЙ НӨӨЦИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН:

A handwritten signature in black ink, appearing to read "А.Оргилсайхан".

А.ОРГИЛСАЙХАН

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
ХУУЛИЙН АЖИЛТАН

A handwritten signature in black ink, appearing to read "Б.Баянзул".

Б.БАЯНЗУЛ

МОНГОЛ УЛСЫГ 2021-2024 ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН
2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
(2023 оны эхний хагас жилийн байдлаар)

2023 оны 06 дугаар сарын 07

Улаанбаатар хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА

Засгийн газрын 2020 оны 206 тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэн “Нийслэлийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ны хэрэгжилтийг 2023 оны нэгдүгээр байдлаар нэгтгэн дүгнэж, хяналт-шинжилгээ үнэлгээ хийлээ.

“Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд нийслэл хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээнээс тус газрын хариуцах 1 арга хэмжээ байна.

Хөтөлбөрт туссан үндсэн хариуцах 1 зорилт арга хэмжээний дундаж 70%-тай байна.

Тус газрын хариуцан хэрэгжүүлэхээр туссан арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 70%-тай байгаа нь 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.3-т заасан үнэлгээний арга зүйгээр “**тодорхой үр дүнд хүрсэн**”-(зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай) үнэлгээтэй байна.

Хэрэгжилт 50-89 хувьтай заалтад:

- Олон төрөлт, ухаалаг нийтийн тээвэр хэрэглээнд нэвтэрсэн байна. Зорчигчдын ариун цэвэр, аюулгүй байдлыг хангасан, нийтийн тээврийн буудалтай байна.
хэрэгжилт 70%

ХОЁР. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ДҮГНЭЛТ

1.Даргын зөвлөлийн хурлаас “Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн дүнтэй холбоотой өгсөн үүрэг даалгаврыг холбогдох хэлтэс, албан хаагчид хүргүүлж, хэрэгжилтэд явцын хяналт тавих;

2.Төлөвлөгөөний хэрэгжилтийг хариуцаж байгаа хэлтсийн дарга, албан хаагчдад Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу тодорхой тоон мэдээ, чанарын үзүүлэлтээр илэрхийлэгдэх, 2000 тэмдэгтэд багтаасан, товч, тодорхой тайлан мэдээг хугацаандаа өгч байхыг анхааруулах, цаашид

арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байгаа шалтгаан нөхцөлийг тодорхойлж, эрчимжүүлж ажиллахыг Даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр холбогдох хэлтэс, нэгжийн дарга нарт үүрэгжүүлэх саналтай байна.

ТАНИЛЦСАН:
ДАРГА

С.ЖАВХЛАНТБААТАР

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

А.ОРГИЛСАЙХАН

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.БОЛОРЦЭЦЭГ



Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

2023 оны хагас жилийн байдлаар

2023 оны 05 дугаар сарын 29

Улаанбаатар хот

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
13	9.3. Хотын төвлөрлийг задгал дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ухаалаг технологийн шинэчлэл хийнэ.	9.3.4. Олон төрөлт, ухаалаг нийтийн тээвэр хэрэглээнд нэвтэрсэн байна. Зорчигчдын ариун цэвэр, аюулгүй байдлыг хангасан, нийтийн тээврийн буудалтай байна.	2021 - 2025	678,700.0	Бүгд Найрамдах Франц Улсын "Пома групп" болон "Эжис Рейл" компанийн хамтарсан түншлэл нь 2022 оны 11 дүгээр сард Дүүжин тээврийн 2 дугаар шугам буюу Наадамчдын өргөн чөлөөг Энхтайваны өргөн чөлөөтэй холбох "Нийслэлийн нутгийн өөрөө удирдах болон Нутгийн захиргааны байгууллагын нэгдсэн цогцолбор-Хар хорин автобусны буудал" 4.2 км урттай чиглэлийг барьж байгуулахаар шийдвэрлэсэн. Дээрх ажлын хүрээнд "Пома групп" болон "Эжис Рейл" компанийн хамтарсан түншлэл нь техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлыг туслан гүйцэтгэгчээр хийлгүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна. Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын явц 80 хувьтай байгаа талаар 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр "Түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл"-өөс зохион байгуулсан уулзалтад мэдээлэл өгсөн. Уг төслийн хоёрдугаар шугамыг эцэслэн тохирсон бөгөөд газрын асуудал бүрэн шийдвэрлэгдэж, төслийг эхлүүлэхээр нэгдсэн төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Мөн "Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл"-ийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан боловсруулж буй стандартын төсөлтэй танилцаж санал боловсруулан Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 01/02/1100 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Тулгуурт гүүрэн байгууламж бүхий хөнгөн галт тэрэг төслийг "Шинэ бүтээн байгуулалт" ХХК хариуцаж байна. Нийтийн тээврийн газраас хамтран ажиллах, мэдээлэл солилцох талаарх саналаа 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 01/02/597 дугаартай албан бичгийг "Шинэ бүтээн байгуулалт" ХХК-д хүргүүлсэн. Тулгуурт гүүрэн байгууламж бүхий Улаанбаатар хотын хөнгөн галт тэрэгний нэгдүгээр чиглэлийн трассын кадастрын зургийн цэг тэмдэг тавих, трассын дагуу инженерийн шугам сүлжээ бүхий байр зүйн зураг боловсруулах зөвлөх үйлчилгээний тендэрт "Геодата" ХХК шалгарсан бөгөөд ажлын тайланг хүлээн авахаар ажиллаж байна.	Хүрсэн түвшин, үр дүн	70

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
<p>Хөдлөх бүрэлдэхүүний вагон депо, удирдлагын төв болон засвар үйлчилгээний барилга, байгууламжийн зориулалтаар 110,06 га газар буюу 35 нэгж талбарыг улсын тусгай хэрэгцээнд авах газрын байршлын координатыг НИТХ-ын 2022 оны 39 дүгээр тогтоолоор батлуулсан.</p> <p>2023 онд шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтын 9 дүгээрт Нийслэлийн нийтийн тээврийн 2 терминал байгуулах зураг боловсруулах ажлын санхүүжилт 1 тэрбум төгрөг батлагдсан. Дээрх ажлын хүрээнд зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж Нийслэлийн бодлогын судалгаа шинжилгээний төвд 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 01/02/811 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих, бэхжүүлэх зорилтын хүрээнд нийтийн тээврийн эцсийн зогсоолын арчлалт ашиглалтыг хариуцах аж ахуйн нэгжийн сонгон шалгаруулалтад шалгарч, Санамж бичиг байгуулсан хувийн хэвшил буюу Дижитал концепт ХХК (GS-25)-д Нийтийн тээврийн үйлчилгээний эцсийн зогсоолыг засварлаж тохижуулах, ашиглалтыг хариуцуулах, гэрээний төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулан Дижитал концепт ХХК-д хүргүүлсэн.</p>							
Хэрэгжилтийн дундаж хувь 70%*1							

ТАНИЛЦСАН:
ДАРГА

ХЯНАСАН:
ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН, АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

НЭГТГЭСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

С.ЖАВХЛАНТБААТАР

А.ОРГИЛСАЙХАН

Б.БОЛОРЦЭЦЭГ

